**ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХӨА-2024/238/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Мөрөн сум
2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг:tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: Г.Ичинхорлоо
Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа
Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com
Аудитор Ц.Мөнхтуяа
Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.26 № 01/150
танай ______-ны № ______-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН БАЯНЗҮРХ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ТҮВШИНБАЯР ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянзүрх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Баянзүрх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар дараах зөрчилтэй зүйл илэрлээ. ***Үүнд:***

- Бараа материалын үлдэгдэлд зах зээлийн үнээс хэт доогуур үнэлгээтэй хөрөнгө бүртгэлтэй, ашиглалтад тавьж олгосон бараа материалыг зарлага болгоогүй нийт 16,459.1 мянган төгрөгийн зөрчил завсрын аудитаар илрүүлж, зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна.
- Танхимаас гадуурх сургалтын зардал, багшийн мэргэжил дээшлүүлэх зардал, цахим хэрэглээний зардал, эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн зардлыг зориулалт, арга хэмжээний дагуу зарцуулаагүй 8,662.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Дээрх зөрчлүүдийг материаллаг хэмжээний зөрчилд тооцсон бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг түвшнээс 1,333.7 мянган төгрөгөөр давсан.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 177,890.2 төгрөг байна.

6724040399

**Аудитын гол асуудал**

Аудитаар нийт 39,608.9 төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,925.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 616.7 төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 36,067.2 мянган төгрөгийн 6 зөвлөмж өглөө.

Хувьсах зардлаар төсвийг төлөвлөж, хуваарилахдаа алслалтын үзүүлэлтийг харгалзаж үзээгүй нь төсвийг зарцуулалтад нөлөөлсөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус сургуулийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааг хариуцсан нягтлан бодогч удаа дараа солигдож, тогтвор суурьшилгүй байгаа нь сөргөөр нөлөөлж байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **268,515,553.44** | **457,006,909.42** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **18,638,799.21** | **177,890,192.35** |
| **31200** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | **18,638,799.21** | **177,890,192.35** |
| **31210** | **Төгрөг** | **18,638,799.21** | **177,890,192.35** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 18,638,799.21 | 177,890,192.35 |
| **33** | **АВЛАГА** | **11,672,000.00** | **1,266,212.60** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 1,266,212.60 |
| **33500** | **Бусад авлага** | **11,672,000.00** | **-** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 11,672,000.00 | - |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **-** | **7,075,000.00** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 7,075,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **238,204,754.23** | **270,775,504.47** |
| **35100** | **Түүхий эд материал** | **709,120.00** | **919,560.00** |
| 35130 | Эм боох материал | 709,120.00 | 919,560.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 5,994,100.40 | 5,994,100.40 |
| **35400** | **Хангамжийн материал** | **229,211,533.83** | **261,346,844.07** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,752,480.00 | 3,806,948.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 178,605,720.22 | 180,625,720.22 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,325,000.00 | 9,515,500.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 30,000.00 | 5,924,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 38,390,373.61 | 45,529,974.01 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 8,107,960.00 | 15,944,201.84 |
| 35600 | Мал амьтад | 2,290,000.00 | 2,515,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,130,075,493.65** | **5,065,246,091.06** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **5,130,075,493.65** | **5,065,246,091.06** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **5,019,940,496.93** | **4,956,161,093.74** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5,367,954,540.93 | 5,367,954,540.93 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -685,940,018.20 | -840,320,837.80 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 15,000,000.00 | 83,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -6,093,750.00 | -6,718,750.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 307,353,800.30 | 340,219,800.30 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -143,894,705.18 | -197,551,313.13 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 177,046,943.16 | 197,253,443.16 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -87,606,453.73 | -114,693,816.17 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,689,000.00 | 52,414,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -3,701,800.00 | -4,138,600.00 |
| 39217 | Ном | 74,132,939.65 | 77,942,626.45 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **110,134,996.72** | **109,084,997.32** |
| 39301 | Программ хангамж | 6,643,745.00 | 6,643,745.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,508,748.28 | -3,558,747.68 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 106,000,000.00 | 106,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,398,591,047.09** | **5,522,253,000.48** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **20,720,159.96** | **46,874,288.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **20,720,159.96** | **2,501,088.00** |
| **41300** | **Өглөг** | **20,720,159.96** | **2,501,088.00** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 7,003,067.55 | 0 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 5,827,392.41 | 2,501,088.00 |
| **41360** | **Бусад өглөг** | **7,889,700.00** | **44,373,200.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 7,889,700.00 | 0.00 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨР** | **-** | **44,373,200.00** |
| **42200** | **Урт хугацаат зээл** | **-** | **44,373,200.00** |
| **42210** | **Төгрөг** | **-** | **44,373,200.00** |
| 42211 | Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | - | 44,373,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,377,870,887.13** | **5,475,378,712.48** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **5,377,870,887.13** | **5,475,378,712.48** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 1,403,305,822.70 | 1,403,305,822.70 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 1,403,305,822.70 | 1,403,305,822.70 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **3,291,733,825.90** | **3,389,241,651.25** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,226,012,918.90 | 3,291,733,825.90 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 65,720,907.00 | 97,507,825.35 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 682,831,238.53 | 682,831,238.53 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,398,591,047.09** | **5,522,253,000.48** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,986,093,807.00** | **2,578,540,485.64** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **65,720,907.00** | **85,285,985.64** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **65,720,907.00** | **85,285,985.64** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **7,943,700.00** | **3,169,757.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,158,700.00 | 3,169,757.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,785,000.00 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 52,967,404.00 | 72,460,686.80 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 4,809,803.00 | 9,655,541.84 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,920,372,900.00** | **2,493,254,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,763,432,900.00** | **2,382,254,500.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,763,432,900.00 | 2,382,254,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **156,940,000.00** | **111,000,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 156,940,000.00 | 111,000,000.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,114,505,954.20** | **2,478,742,660.29** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,114,505,954.20** | **2,478,742,660.29** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,004,873,418.90** | **2,425,119,330.36** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,309,535,588.24** | **1,621,454,640.49** |
| 210101 | Үндсэн цалин | 973,631,261.56 | 1,103,297,602.02 |
| 210102 | Нэмэгдэл | 237,174,892.42 | 398,403,248.84 |
| 210104 | Урамшуулал | 98,729,434.26 | 119,753,789.63 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **163,463,800.00** | **201,322,190.32** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 111,569,496.17 | 142,107,374.35 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,257,083.05 | 15,082,637.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,186,297.82 | 12,041,873.84 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,532,394.19 | 3,000,869.15 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,918,528.77 | 29,089,435.16 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **102,772,392.59** | **92,591,468.06** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,517,392.41 | 34,789,788.06 |
| 210302 | Түлш, халаалт | 79,255,000.18 | 54,805,780.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,000,000.00 | 2,995,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **36,773,129.75** | **46,023,340.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 10,118,466.36 | 16,681,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,236,700.00 | 17,034,340.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 457,300.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,123,199.99 | 12,307,700.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,837,463.40 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **113,090,807.45** | **202,129,602.10** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,873,363.00 | 789,860.00 |
| 210502 | Хоол, хүнс | 108,817,444.45 | 201,339,742.10 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 400,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **20,259,800.00** | **1,856,500.00** |
| 210604 | Урсгал засвар | 20,259,800.00 | 1,856,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **11,385,700.00** | **10,032,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,158,700.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,227,000.00 | 10,032,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **247,592,200.87** | **249,709,589.39** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,558,100.00 | 10,718,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,580,000.00 | 1,755,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 230,454,100.87 | 237,236,589.39 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **109,632,535.30** | **53,623,329.93** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **109,632,535.30** | **53,609,722.40** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 92,077,335.30 | 37,753,487.50 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,555,200.00 | 15,856,234.90 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **-** | **13,607.53** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 13,607.53 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **65,720,907.00** | **99,797,825.35** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **-** | **2,290,000.00** |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | - | 2,290,000.00 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | **65,720,907.00** | **97,507,825.35** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,923,531,600.00** | **2,496,424,257.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,158,700.00** | **3,169,757.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **3,158,700.00** | **3,169,757.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **3,158,700.00** | **3,169,757.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,158,700.00 | 3,169,757.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,920,372,900.00** | **2,493,254,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,763,432,900.00** | **2,382,254,500.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,763,432,900.00 | 2,382,254,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **156,940,000.00** | **111,000,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 156,940,000.00 | 111,000,000.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,859,890,100.79** | **2,285,310,363.86** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,859,890,100.79** | **2,285,310,363.86** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,751,968,183.69** | **2,166,676,061.43** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,302,557,887.69** | **1,621,935,061.27** |
| 210101 | Үндсэн цалин | 966,628,194.01 | 1,103,297,602.02 |
| 210102 | Нэмэгдэл | 237,200,259.42 | 398,883,669.62 |
| 210104 | Урамшуулал | 98,729,434.26 | 119,753,789.63 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **163,463,800.00** | **209,111,119.69** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 111,012,939.57 | 142,393,124.69 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,220,260.93 | 16,764,798.84 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,461,700.00 | 13,355,079.05 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,614,700.00 | 3,341,901.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 26,154,199.50 | 33,256,215.44 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **67,690,000.00** | **100,995,692.47** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,690,000.00 | 38,116,092.47 |
| 210302 | Түлш, халаалт | 50,000,000.00 | 59,883,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,000,000.00 | 2,995,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | **126,821,446.00** | **142,579,300.00** |
| 210502 | Хоол, хүнс | 126,821,446.00 | 142,579,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **15,000,000.00** | **9,990,700.00** |
| 210604 | Урсгал засвар | 15,000,000.00 | 9,990,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **12,394,250.00** | **12,120,968.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,158,700.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,235,550.00 | 12,120,968.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **64,040,800.00** | **69,943,220.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 46,997,100.00 | 51,524,020.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 17,043,700.00 | 18,419,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **107,921,917.10** | **118,634,302.43** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **107,921,917.10** | **118,620,694.90** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 93,150,717.10 | 102,764,530.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 14,771,200.00 | 15,856,164.90 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **-** | **13,607.53** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 13,607.53 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **63,641,499.21** | **211,113,893.14** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **45,002,700.00** | **51,862,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **45,002,700.00** | **51,862,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **45,002,700.00** | **51,862,500.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 45,002,700.00 | 51,862,500.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-45,002,700.00** | **-51,862,500.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **18,638,799.21** | **159,251,393.14** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 18,638,799.21 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 18,638,799.21 | 177,890,192.35 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,403,305,822.70** | **682,831,238.53** | **3,226,012,918.90** | **5,312,149,980.13** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,403,305,822.70 | 682,831,238.53 | 3,226,012,918.90 | 5,312,149,980.13 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 65,720,907.00 | 65,720,907.00 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,403,305,822.70** | **682,831,238.53** | **3,291,733,825.90** | **5,377,870,887.13** |
| **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,403,305,822.70** | **682,831,238.53** | **3,291,733,825.90** | **5,377,870,887.13** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,403,305,822.70 | 682,831,238.53 | 3,291,733,825.90 | 5,377,870,887.13 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 97,507,825.35 | 97,507,825.35 |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,403,305,822.70** | **682,831,238.53** | **3,389,241,651.25** | **5,475,378,712.48** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Улсын төсвийн гүйцэтгэл:** / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Биелэлт | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,409,172,300.00** | **2,226,172,863.86** | **92.40** | **182,999,436.14** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,409,172,300.00** | **2,226,172,863.86** | **92.40** | **182,999,436.14** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,276,524,000.00** | **2,107,552,168.96** | **92.58** | **168,971,831.04** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,769,241,400.00** | **1,621,935,061.27** | **91.67** | **147,306,338.73** |
| 210101 | Үндсэн цалин | 1,187,050,400.00 | 1,103,297,602.02 | 92.94 | 83,752,797.98 |
| 210102 | Нэмэгдэл | 488,253,000.00 | 398,883,669.62 | 81.70 | 89,369,330.38 |
| 210104 | Урамшуулал | 93,938,000.00 | 119,753,789.63 | 127.48 | -25,815,789.63 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **221,154,800.00** | **209,111,119.69** | **94.55** | **12,043,680.31** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 150,385,300.00 | 142,393,124.69 | 94.69 | 7,992,175.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,692,300.00 | 16,764,798.84 | 94.76 | 927,501.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,153,900.00 | 13,355,079.05 | 94.36 | 798,820.95 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,538,500.00 | 3,341,901.67 | 94.44 | 196,598.33 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 35,384,800.00 | 33,256,215.44 | 93.98 | 2,128,584.56 |
| **2105** | **Нормативт зардал** | **142,579,300.00** | **142,579,300.00** | **100.00** | **0.00** |
| 210502 | Хоол, хүнс | 142,579,300.00 | 142,579,300.00 | 100.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **20,408,300.00** | **12,120,968.00** | **59.39** | **8,287,332.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,128,900.00 | 0 | 0 | 8128900 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 12,279,400.00 | 12,120,968.00 | 98.71 | 158,432.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **123,140,200.00** | **121,805,720.00** | **98.92** | **1,334,480.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 104,721,000.00 | 103,386,520.00 | 98.73 | 1,334,480.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 18,419,200.00 | 18,419,200.00 | 100.00 | 0.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **132,648,300.00** | **118,620,694.90** | **89.42** | **14,027,605.10** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **132,648,300.00** | **118,620,694.90** | **89.42** | **14,027,605.10** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 116,685,000.00 | 102,764,530.00 | 88.07 | 13,920,470.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,963,300.00 | 15,856,164.90 | 99.33 | 107,135.10 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,409,172,300.00** | **2,385,424,257.00** | **99.01** | **23,748,043.00** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,382,254,500.00** | **2,382,254,500.00** | **100.00** | **0.00** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,382,254,500.00 | 2,382,254,500.00 | 100.00 | 0.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **26,917,800.00** | **3,169,757.00** | **11.78** | **23,748,043.00** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,128,900.00 | 3,169,757.00 | 38.99 | 4,959,143.00 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 150,000.00 | 0 | 0 | 150000 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 18,638,900.00 | 0 | 0 | 18638900 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 18,638,799.21 | | -18,638,799.21 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 177,890,192.35 | | -177,890,192.35 |

**Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:** /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Биелэлт | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **111,000,000.00** | **110,986,392.47** | **99.99** | **13,607.53** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **111,000,000.00** | **110,986,392.47** | **99.99** | **13,607.53** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **111,000,000.00** | **110,986,392.47** | **99.99** | **13,607.53** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **101,000,000.00** | **100,995,692.47** | **100.00** | **4,307.53** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 33,000,000.00 | 32,999,955.48 | 100.00 | 44.52 |
| 210302 | Түлш, халаалт | 65,000,000.00 | 64,999,836.99 | 100.00 | 163.01 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,000,000.00 | 2,995,900.00 | 99.86 | 4,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **10,000,000.00** | **9,990,700.00** | **99.91** | **9,300.00** |
| 210604 | Урсгал засвар | 10,000,000.00 | 9,990,700.00 | 99.91 | 9,300.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **111,000,000.00** | **110,986,392.47** | **99.99** | **13,607.53** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **111,000,000.00** | **110,986,392.47** | **99.99** | **13,607.53** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 111,000,000.00 | 110,986,392.47 | 99.99 | 13,607.53 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 560,188.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэн. Үүнд:

- Санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 39,608.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,925.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 616.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 36,067.2 мянган төгрөгийн 6 зөвлөмжийг хүргүүлсэн.
- Нийцлийн аудитад хамааралтай 520,579.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар нийт 2,925.0 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулсан.

**Залруулсан алдаа**:

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Малын нас дэвшилтийг бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "үнэн зөв байх;" заалттай нийцэхгүй, "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад 225.0 мянган төгрөгөөр залруулсан.
- Багш нарын дата хэрэглээний 2024 оны 1-р улирлын зардлыг урьдчилан төлж, тайлант үеийн зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "жинхэнэ хэрэгжилтийн" зарчимтай нийцэхгүй "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул 2,700.0 мянган төгрөгийн залруулга хийсэн.

Аудитаар нийт 557,263.8 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 616.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 520,579.9 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 36,067.2 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 36,683.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 23,188.2 мянган төгрөгөөс 13,495.7 мянган төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

Нийтээр амрах баярын өдөр таарсан ээлжийн ажилтны цалин болон төрд алба хаасан хугацааны нэмэгдлийг 616.7 мянган төгрөгөөр илүү тооцоолж олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.9 "Ээлжээр ажилладаг ажилтны ээлж долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарсан бол энэ хуулийн 109.2, 109.4-т заасан нэмэгдэл хөлс олгохгүй. Харин хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр нэмэгдэл хөлс тогтоож болно." заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 1 дүгээр хавсралтаар баталсан хувь хэмжээтэй нийцэхгүй, "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.2 Албан шаардлага

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь, бүрэн байршуулах өмнөх оны аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 11, зарлагын 3 мэдээллийг байршуулаагүй байгаа 520,579.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэснийг энэ тайлангийн 4.4.1-д дэлгэрэнгүй тусгасан.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Тус сургуулийн үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 109 нэр төрлийн 140,580.7 мянган төгрөгийн 275 хөрөнгө бүртгэлтэй байгаа нь УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө"-ийн параграф 67, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

санхүүгийн тайлан гаргах;" заалт болон ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийн 7.1 заалттай тус тус нийцээгүй, "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ОНӨГ-т хүргүүлэн шийдвэрлүүлж, үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгах

2. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u>*

Танхимаас гадуурх сургалтын зардал, багшийн мэргэжил дээшлүүлэх зардал, цахим хэрэглээний зардал, эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй 8,662.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;" заалт, БШУС-ын 2019 оны А/170 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх заавар, аргачлал", Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"–ын хавсралтад заасан зориулалт, арга хэмжээтэй нийцэхгүй "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Төсвийг батлагдсан зориулалт, арга хэмжээний дагуу, холбогдох хууль, журам, зааварт нийцүүлэн зарцуулж байх.

3. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u>*

Тус сургуулийн аудит хийлгэхээр ирүүлсэн 2023 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүнийг шалгаж үзэхэд санхүүгийн тайлангийн тодруулга, худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг гаргаж ирүүлээгүй нь төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4.5 "санхүүгийн тайлангийн тодруулга", 54.5.3 "тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;" заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан бүрэлдэхүүнээр бүрэн бэлтгэдэг байх.

4. Өр, төлбөртэй холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u>*

Тус сургууль нь тайлант жилийн эцэст нийгмийн даатгалын шимтгэлийг 1,266.2 мянган төгрөгөөр илүү шилжүүлж авлага үүсгэсэн, гэрэл цахилгааны зардалд 2,501.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." заалттай нийцэхгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Төсвийн гүйцэтгэлд сар бүр дүн шинжилгээ хийж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, үүссэн өр төлбөрийг барагдуулах.

5. Газрын бүртгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Тус сургуулийн эзэмшил газрын нягтлан бодох бүртгэлд тусгасан хэмжээ, кадастрын зураг, газрын гэрчилгээнд тусгасан хэмжээнээс 3,589 кв.м, 7,178.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлд газрыг үнэн зөвөөр бүртгэж, залруулах.

6. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Бараа материалын үлдэгдэлд зах зээлийн үнээс хэт доогуур үнэлгээтэй хөрөнгө бүртгэлтэй, ашиглалтад тавьж олгосон бараа материалыг зарлага болгоогүй нийт 16,459.1 мянган төгрөгийн зөрчил завсрын аудитаар илрүүлж, зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Хөрөнгийн ашиглалтын байдалд дүгнэлт өгч, цаашид ашиглах хөрөнгийн үнэлгээг зах зээлийн үнэд ойртуулах, ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглахгүй хөрөнгийг акталж, данснаас хасах.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Зардал урьдчилж төлсөн | 1 | 2,700.0 | | | 1 | 2,700.0 | | | | | | |
| Малын нас дэвшилт хийгээгүй | 1 | 225.0 | 1 | 225.0 | | | | | | | | |
| **Дүн** | **2** | **2,925.0** | **1** | **225.0** | **1** | **2,700.0** | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Дүн | Тоо | Дүн | Тоо |
| Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө нягтлан бодох бүртгэлд бүртгэлтэй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Зардлын зориулалт, арга хэмжээнд нийцүүлж зарцуулаагүй байна. | 1 | 8,662.8 | | | | | 1 | 8,662.8 |
| Газрын хэмжээ зөрүүтэй | 1 | 7,178.0 | | | | | 1 | 7,178.0 |
| Цалин илүү олгосон | 1 | 616.7 | 1 | 616.7 | | | | |
| Өр, авлага үүсгэсэн | 1 | 3,767.3 | | | | | 1 | 3,767.3 |
| Бараа материалын бүртгэлтэй холбоотой завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй | 1 | 16,459.1 | | | | | 1 | 16,459.1 |
| Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн дутуу | 1 | | | | | | 1 | |
| **Дүн** | **7** | **36,683.9** | **1** | **616.7** | | | **6** | **36,067.2** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 11,зарлагын 3 мэдээлэл оруулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй | 1 | 520,579.9 | | | 1 | 520,579.9 | | |
| **Дүн** | **1** | **520,579.9** | | | **1** | **520,579.9** | | |

## 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 09 сарын 26 өдөр № 98/A2270439/ХӨА-2024/238/ИА-СТА-ТШ3 Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Баянзүрх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 520,579,865(таван зуун хорин сая таван зуун далан есөн мянга найман зуун жаран тав) төгрөгийн 14 мэдээлэл мэдээлээгүй байна.
2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д *"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"*, 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "*Аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй*", 4.2.1.11-т "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно*" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж, илэрсэн зөрчлийг арилгаж биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэх;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Түвшинбаяр, нягтлан бодогч Ө.Баасанхүү нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

"ИХЭР МӨРӨН АУДИТ"ХХК
ЗАХИРАЛ Б.МЯДАГМАА

[1] Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр, 3 давхар, 303 тоот

6724030099

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АКТ

2024 оны 02 сарын 26 өдөр　　№ 45/А2970439/ХӨА-2024/238/НА-СТА-ТШЗ　　Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Баянзүрх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нийтээр амрах баярын өдөр таарсан ээлжийн ажилтны цалин болон төрд алба хаасан хугацааны нэмэгдлийг зөрүүтэй тооцоолж 616,738 /зургаан зуун арван зургаан мянга долоон зуун гучин найм/ төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.9-т "Ээлжээр ажилладаг ажилтны ээлж долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарсан бол энэ хуулийн 109.2, 109.4-т заасан нэмэгдэл хөлс олгохгүй. Харин хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр нэмэгдэл хөлс тогтоож болно.", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 2-т "Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно: ....", гэж заасантай нийцэхгүй, "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *"Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3. *"цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"* гэсэн заалтуудыг үндэслэн

**ТОГТООХ нь:**

1. Илүү тооцож олгосон цалин хөлс 616,738 /зургаан зуун арван зургаан мянга долоон зуун гучин найм/ төгрөгийг хавсралтад заасан нэр бүхий ажиллагсдаас суутган тооцож Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар[1]т нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Түвшинбаяр, нягтлан бодогч Ө.Баасанхүү нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР　　А.ЭРДЭНЭБААТАР

"ИХЭР МӨРӨН АУДИТ"ХХК
ЗАХИРАЛ　　Б.МЯДАГМАА

---

[1] Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот

6724020145

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын
2024 оны 02 дугаар сарын 26 –ны өдрийн
45/А2270439/ХӨА-2024/238/АА-СТА-ЛШ3
төлбөрийн актын хавсралт

720000001 - 3070605

# ТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

| № | Овог | Нэр | Төрд ажилласан жилийг илүү тооцож олгосон | Нийтээр амрах баярын өдөр ажилласны нэмэгдэл хөлс |
|---|---|---|---|---|
| 1 | Аюурзана | Чингүнжав | | 29,473.0 |
| 2 | Баатар | Чулуун | | 12,847.0 |
| 3 | Батжаргал | Буянбат | | 13,482.0 |
| 4 | Баттөр | Дуламжав | | 13,981.0 |
| 5 | Батцэрэн | Дэлгэрмаа | | 27,605.0 |
| 6 | Баяраа | Лхагвадорж | | 17,447.0 |
| 7 | Баяраа | Лхагвасүрэн | | 13,482.0 |
| 8 | Дамдинжав | Нямдэлгэр | | 17,447.0 |
| 9 | Должмаа | Гантөмөр | | 13,482.0 |
| 10 | Жаргалсайхан | Даваадэлгэр | | 13,459.0 |
| 11 | Жижигхүү | Давааням | 50,256.0 | |
| 12 | Жүрмэд | Мөнхцэцэг | | 13,459.0 |
| 13 | Идэрхүү | Шинэхүү | | 13,482.0 |
| 14 | Марууш | Батрагчаа | | 34,894.0 |
| 15 | Мархаа | Бямбацогт | | 34,894.0 |
| 16 | Мачуухай | Ариунаа | | 13,981.0 |
| 17 | Морхууз | Нямдаваа | | 17,447.0 |
| 18 | Налгар | Нямдаваа | | 17,447.0 |
| 19 | Ноост | Одончимэг | | 14,646.0 |
| 20 | Одгэрэл | Оюунбилэг | | 14,124.0 |
| 21 | Осорбат | Гарамлхамжав | 82,238.0 | |
| 22 | Өвгий | Наранбаатар | | 34,894.0 |
| 23 | Санзай | Чинбат | | 18,093.0 |
| 24 | Санзай | Оюунбат | | 26,306.0 |
| 25 | Сарантуяа | Бямбажав | | 14,124.0 |
| 26 | Сүхээ | Лхагва-Очир | | 17,447.0 |
| 27 | Хөхрөн | Нямбаяр | | 26,306.0 |
| | | | **132,494.0** | **484,244.0** |
| | **Нийт** | | **616,738.0** | |

oooOooo